

## ЯПОНЫ ДИПЛОМАТ ЁСЛОЛЫН ОНЦЛОГ

Ж. Батжаргал\*

**Abstract:** *In this article the author aimed to give the audience comprehensive understanding about the peculiarities of Japanese diplomatic protocol, uniqueness of culture, historical tradition of diplomatic protocol. Japan is one of the highly developed countries and has rich cultural heritage. The paper explains Japanese unique cultural features including bowing, seat orders in diplomatic ceremony, seating allocations in diplomatic receptions and etiquettes followed during diplomatic receptions. The first part of the article provides the overview of Japanese diplomatic protocol's history, exponents in Japanese style dialogue and bowing. The second part of the article discusses seat orders in Japanese diplomatic ceremony and using Japanese national flag during diplomatic meetings. The third part includes Japanese diplomatic ceremonial rules. The conclusion presents the researcher's recommendation for research gap and practical issues.*

**Key words:** *Japanese diplomatic protocol, Japanese culture, Japanese business etiquette, Japanese gestures, diplomatic practice, diplomatic ceremonial and protocol*

### Оршил

Дипломат ёс горим, ёслол бол олон улсын харилцааны янз бүрийн салбар тэр дундаа дипломат ажилтан, гадаад харилцааны чиглэлийн оюутан, судлаач, төрийн түшээ, албан хаагч хэн бүхэн мэдэж, мөрдөж, дагавал зохих нарийн зүй тогтол, хэв маяг, хэлбэр, агуулга бүхий өвөрмөц асуудал юм. Ёслолын аливаа арга хэмжээнд дотоод гадаадын төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн урилгаар оролцох нь нэлээн түгээмэл болж байгаа бөгөөд дипломат ёс, ёслолын журмыг сахиж хүндэтгэж, түүнд тодорхой мэдлэг, мэдрэмжтэйгээр оролцохыг шаарддаг. Дипломат ёс, ёслол, ёслолын журам, дэг жаягийг сахиж хүндэтгэх нь аливаа улс орнууд найрсаг харилцаатай байж, олон улсын эрхзүйн хэм хэмжээг сахин мөрдөхөд чухал ач холбогдолтой юм. Ли Бо “Дипломат ажиллагаа” номондоо “дипломат ёс журам”-ыг дүрэм журам, илүү өндөр байр суурьтай байх, журам, улс гүрнүүд хоорондын албан ёсны харилцааны хэлбэрүүд гэж тодорхойлжээ.<sup>1</sup>

Тухайлбал, гадаадын улс гүрний туг, сүлд, төрийн зүтгэлтнүүдийг хэрхэн хүндэтгэж, дипломатын болон консулын дархан эрх, эрх ямбыг дагаж мөрдөж байгаагаар тухайн улс орны хоорондын харилцааны төвшинг ямар нэг хэмжээгээр тодорхойлж болдог тал бий.

Энэхүү өгүүлэлдээ өнө эртний түүхтэй, соёлын асар их баялаг өвтэй, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын нэг болох Япон улсын соёлын өвөрмөц онцлог, дипломат ёслолын түүхэн уламжлал, япончуудын өвөрмөц соёл болох мэндлэх хүндлэх ёсон, дипломат ёслолын суудлын дараалал, хүлээн авалтын суудлын хуваарилалт, япон зоогийн ширээний

---

\* Судлаач, (МВА, Олон улсын харилцааны магистр) batjargalmc@gmail.com

<sup>1</sup> Li, B. (2014). Diplomacy (p. 241). Beijing: Current Affairs Press

ард баримтлах горим, нэрийн хуудас солилцох талаар хөндөн авч үзэж багтаасан болно. Мөн элчин сайд нар Япон улсын цог жавхлантай эзэн хаанд итгэмжлэх жуух бичиг барих ёсон, Япон улсын төрийн далбааг уулзалт хэлэлцээнд хэрхэн хэрэглэдэг тухай, гадаадын дээд болон өндөр хэмжээний төлөөлөгчдийн айлчлалыг хэрхэн бэлдэж зохион байгуулдаг тухай багтаав.

## **Удиртгал**

Зочдыг угтах, үдэх, хурал цуглаан, уулзалт яриа хэлэлцээнд оролцох суудлын эрэмбэ дараалал зэрэг асуудлаар удаан хугацаанд тогтсон журам байгаагүйн уршгаар улс гүрнүүдийн дипломат төлөөлөгчдийн дунд хурц маргаан болж байснаар барахгүй, зэвсэг хэрэглэн хүний амь үрэгдэх золгүй явдал дипломатын түүхэнд цөөнгүй гарч байжээ. Жишээлбэл, 1661 онд Шведийн элчин сайдыг Лондонд хүрэлцэн ирэхэд түүнийг түрүүлж угтахаар байр дараалал булаацалдан Испани болон Францын элчин сайдуудын зарц нар хоорондоо маргалдаж улмаар сэлэм сугалан цавчилдаж, олон хүний амь насыг бүрэлгэх явдал гарч байсан түүхтэй.<sup>2</sup>

АНУ, Францын нэрт судлаачид болох Жон Вүүд, Жан Серре нарын тэмдэглэснээр дипломат ёслолын алдаа нь тухайн дипломат буюу төрийн зүтгэлтэнд үл итгэж байгаагийн албан ёсны илэрхийлэл гэж тооцох ёстой гэдгийг дипломат үйл ажиллагаанд оролцогч хүн бүр санаж явууштай. *“Ёслол нь уулзалт цуглааны үеэр таатай уур амьсгал буй болж, оюун ухаанаа хэт дайчлахгүйгээр хоёр талын найрсаг харилцааг хөгжүүлж, уг уулзалт яриа хэлэлцээг үр дүнтэй болгоход хувь нэмрээ оруулдаг”*.<sup>3</sup>

## **Нэг. Японы дипломат ёс горим, ёслолын үүсэл хөгжил**

Аливаа улс орны дипломат ёслолын түүхэн уламжлал нь тухайн улс орны түүх, соёлын үүсэл хөгжилтэй салшгүй холбоотой юм. Японы дипломат ёслол өөрийн түүх соёлтойгоо хэрхэн холбоотойг тоймлон авч үзье.

Японы түүхийг дараах байдлаар үе шат болгон хуваадаг. Үүнд: Балар эртний ба эртний түүхэн үе, феодалын түүхэн үе, шинэ ба шинэхэн үе гэж үндсэн хэдэн үед хуваахын хамт дотор нь түүхэн онцлог үйл явцаар зааглан 10 гаруй тодорхой хугацааны үе шат болгон хуваадаг.

### *1. Эртний түүхэн үе:*

Японы эртний түүхийн үе бол манай эриний өмнө 8000 жилээс 11-р зууныг хамардаг. Энэ эртний үе нь дотроо Жомон, Яёи, Кофун, Ямамото, Нара үе гэж хуваагддаг. МЭӨ 200-гаад оны үед Солонгосын хойгоос Япон руу булаан эзлэгчид довтолж эхэлсэн ба Солонгосын

---

<sup>2</sup> М. Дүгэрсүрэн О. Хосбаяр Дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс УБ 1998 он 222 дахь тал

<sup>3</sup> John Wood, Jean Serres “Diplomatic Ceremonial and Protocol” (Principles, Procedures and Practice) NY, 1970

соёл нэвтэрч эхэлсэн байна.<sup>4</sup> Кофуны үед (МЭ 300-710) он цол хэргэм бий болсон ба нийгмийн давхаргыг бий болгов. Японы нутаг дээр салангид бие даан оршиж байсан 100 гаруй том, жижиг аймгууд Ямото нэртэй овгийн холбооны удирдлаган дор нэгдсэн байсан ба энэхүү овгийн холбооны суурин дээр Японы төр улс бүрэлдэн тогтохын хажуугаар төрийн ёслол үүсэн бий болж эхэлжээ. Япон оронд бараг 6-р зууныг дуустал Хятадын Тан улсын нөлөө хүчтэй байжээ. Япончууд Хятадаас соёлын маш их өвийг дамжуулан авч хэрэглэсэн бөгөөд төрт ёс, засаглалын хэлбэрийг хуулбарлан өөрийн нөхцөл байдалд тохируулан хэрэглэсэн байна. Япончууд Хятадын Сүн болон Тан улс руу элч илгээж харилцаа тогтоож байсан ба Сүн улсын үед дөрвөн удаа, Тан улсын үед арван есөн удаа элч илгээж байжээ. Жишээ нь, тухайн үед Хятадад үүссэн 6 яамыг 8 болгон хэрэглэжээ. Нарагийн үед (710-714 он) Япон орон даяар төр төр улсын хууль журам тогтоох явдал нэлээн өргөжсөн ажээ.<sup>5</sup> Харин 894 оноос хойш Японоос элч төлөөлөгчдийг Тан улс руу явуулахыг зогсоосноос эх газрын соёл Японд нэвтрэн ирэх явдал хумигдаж, 10-р зуунд Японы өөрийнх нь соёл дагнан хөгжсөн ажээ.

## *2. Феодалын түүхэн үе*

Японы феодалын түүхэн үед 12-16-р зууныг дуусталх үеийг хамруулдаг. Энэхүү феодалын үе нь Хэйан үеийн сүүлчээс эхэлдэг бөгөөд дотроо Камакура, Мурамачи гэсэн хоёр үеийг багтаадаг. Феодалын түрүү үе, хожуу үе буюу хөгжингүй үе ч хэмээн хувааж үздэг тал бас бий. Камакурагийн үед (1185-1333) Шёогүн хэмээх цэргийн цол бий болсон ба цэргийн захиргаатай засгийн газар байшуулагдаж байв. Камакурагийн дараагаар “Мурамачи”-гийн үе эхэлдэг ба (1333-1568) энэ үед цэрэг-улс төр, соёлын олон гарамгай үйл явдлуудаар алдаршсан ба соёлын маш их дэвшилт гарсан. 1543 онд Португалчууд анх өмнөд Кюүшүд ирсэн ба энэ үед Христийн шашин дэлгэрч эхэлсэн байна. Токүгава овгийн шёогүн Хидэдата 1613 онд христос шашныг хориглон Португаль, Испани хар лам нарыг нутгаасаа хөөн гаргасан ба энэ үеийн онцлог нь Япон орон 200 гаруй жилийн турш хаагдмал байсанд оршино.

## *3. Орчин үе*

Японд Токүгавагийн эриний сүүлчээс (1600-1687) Мэйжи эриний эхэн хүртэл өндөр хөгжилтэй орнуудтай найрсаг харилцааны гэрээ хэлэлцээр хийх үест хэдийнэ Азийн улс орнуудад дэлгэрч байсан ёслол мөн орж ирсэн байлаа. 1854 онд Америк, Англи, Франц, Голланд, Орос зэрэг бусад орнуудтай худалдааны гэрээ байгуулжээ. Ийнхүү Япон орон нээлттэй болсон нь хэдэн зуун жилийн турш хаалттай байсан Японд гадны буюу Европын соёл нилээд хүчтэй нөлөөлсөн нь дамжиггүй. Тухайлбал, анх 1600 онд Английн далайчин Адамс Кюүшү аралд ирсэн ба 1858 онд Англитай дипломат харилцаа тогтоосноор Английн соёл иргэншил нэвтэрч эхэлсэн түүхтэй. Эзэн хаан Мэйжигийн үе 1868-1912 оны хоорондох 44 жилийн хугацааг хамардаг ба энэ үед улстөр, цэрэг, нийгэм эдийн засгийн олон арга

<sup>4</sup> Lonely Planet Japan 6<sup>th</sup> edition 1997 p 12

<sup>5</sup> Edwin O. Reischauer “The Japanese” p 42

хэмжээ, өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлсэн байна. Японы түүхээс харахад Япон орон нь эх газраас далайгаар тусгаарлагдсан байршилтай арлын орон учраас гадны хүчний халдлага, довтолгоонд өртөхгүй, өөрөөр хэлбэл нэлээд хаалттай байсан байна. Японы орчин үеийн түүхэн замналыг 19-р зууны сүүлчээс эдүгээг хүртэлх цаг хугацаагаар авч үздэг бөгөөд дотор нь шинэ ба шинэхэн үе гэж хуваадаг. Дэлхийн 1-р дайны дараа Япон улс милитарист шинжтэй гадаад бодлогыг явуулж Герман, Итали зэрэг Европын улс орнуудтай цэргийн эвсэл холбоонд нэгдэж, гэрээ хэлэлцээр байгуулж байсан нь олон улсын болон Европын дипломат дэг жаяг нэвтэрч эхэлсэн. 1926 онд хаан ширээнд суусан эзэн хаан Шёва Европоор явж Британийн соёлыг сонирхон улмаар дэлгэрүүлсэн байна. Энэ үед Английн дипломат ёслол нэлээн дэлгэрсэн байна. Японы түүхийг тодорхойлдог хоёр гол онцлог зүйл байх бөгөөд нэгдэх нь нэг түмэн жилийн туршид соёл бүрэлдэн тогтох явц тасралтгүй үргэлжилсэн явдал, хоёр дахь нь гадаадын соёл болон технологийг өөрсдийн амьдралд оруулж хэрэглэсэн явдал юм.

### *1.1 Мэндлэх хүндлэх ёсон*

Японы уламжлалт мэндлэх ёсонд гар барьдаггүй харин бүсэлхийнээсээ эхлэн бөхийж мэндчилдэг. Үүнийг японоор “ожиги” гэж нэрлэдэг ба хүндлэх гэсэн утгатай.<sup>6</sup> Хэрэв япон хүн тантай бөхийн мэндчилбэл та хариуд нь мөн бөхийн хүндэтгэл үзүүлэх нь зүйтэй. Энэхүү ёс нь дэлхийд их алдартай ба мэндлэх талархал илэрхийлэх, салж явах болон уучлал, хүлцэл өчих үед хэрэглэгдэнэ. Өглөөний мэнд буюу “охайо”, өдрийн мэнд буюу “конничива”, баярлалаа буюу “аригато”, баяртай буюу “саяонара” болон уучлаарай буюу “сүмимасэн” гэж хэлэх үед хэрэглэгдэнэ. Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн хоорондоо бөхийн мэндчилэх үед эмэгтэй нь хоёр гараа урдаа аван нуруугаараа эрэгтэйгээсээ арай илүү бөхийх ба эрэгтэй нь хоёр гараа хоёр хөлөндөө наан толгойгоороо үл ялиг бөхийнө. Хүмүүсийн хоорондын холбоо, хамаарал мөн мөн түүнчлэн тухайн нөхцөл байдлаас хамааран бөхийн мэндчилж байгаа байдал их бага хэмжээгээр ялгаатай байна. Нөхцөл байдлаас хамааран хэд хэдэн янзаар мэндчилдэг. Үүнд:

- Найз нөхөдтэйгээ гараараа даллан “сайн байна” уу гэж хэлэн мэндчилэх
- Хажуугаар зөрж өнгөрөхдөө толгойгоо үл ялиг бөхийлгөн мэндчилэх
- Маш хүндэтгэлтэйгээр толгойгоо бөхийлгөн мэндчилэх гэсэн хэлбэрүүд багтана.

Япончууд хүнтэй анх танилцахдаа “Хажимэ машинтэ” гэж хэлээд өөрийнхөө нэрийг хэлж бөхийн мэндчилнэ. Мөн талархал илэрхийлэхдээ “аригато” буюу баярлалаа гэж хэлдэг ба энэ үгний өмнө “домо” гэж хэлж бас болно. Энэ хоёр үгний дараа “гозаймасү” гэж хэлэх юм бол илүү хүндэтгэлтэй хандаж байгаа хэлбэр юм. Япон хэлэнд уучлал, хүлцэл өчихдөө хэрэглэдэг олон үг байдаг. Жишээ нь: “гомэннасай”, “сүмимасэн” г.м. “Мошивакэ

---

<sup>6</sup> Japan Tourist Bureau “A look into Japan” 1997 p 110

аримасэн” гэвэл илүү их хүндэтгэлийн үг юм. Япон хэлний нэг онцлог нь хүндэтгэлийн үг хэллэг байдаг ба үүнийгээ аливаа хүндлэлд хэрэглэнэ. Хүндэтгэлийн хэлийг дотор нь:

- “Сонкэй-го” (Хүндэтгэлтэй хандах хэллэг)
- “Кэнжо-го” (Номхон дөлгөөн даруу хэллэг)
- “Тэйнэй-го” (Эелдэг хэллэг) гэж ангилдаг.

Хүндэтгэлийн хэлийг голдуу өөрөөсөө насаар ахмад хүнтэй болон албан тушаал дээгүүр хүнтэй харилцахад хэрэглэдэг. Татами буюу японы уламжлалт дэвсгэр дээр бөхийн сууж мэндлэхэд баримталдаг ёс байдаг. Хүндэтгэлтэй байдлаар мэндчилэхэд татами дээр сөхөрч суугаад биеийнхээ дээд хэсгээр 20-30 сантиметр урагш тонгойн хоёр гарынхаа алгаар тулах ба хоёр алганы хооронд 10 сантиметр зай гаргана.

Жирийн мэндчилгээнд гарынхаа хуруунуудыг дэвсгэрт хүргэн урагш 15 градус бага зэрэг бөхийнө. Харин нүүрээрээ эгцлэн харж хоёр гараа хүрэмнийхээ халаасанд хийж суух нь зохимжгүйд тооцогдоно. Мөн бөхийхдөө толгойгоороо дэвсгэрт хүрэх нь зохимжгүй.

### *1.2 Япон маягийн яриа хэлцээний хэв шинж*

Япон хүн ярилцаж буй хүндээ хүндэтгэл илэрхийлэх тохиолдолд биеийн хөдөлгөөндөө гойд анхаардаг ба хоёр гараа өвдгөн дээрээ тавиад, шаардлагатай бол урагш нь бөхийж байгаад нөгөө хүндээ хүндэтгэл илэрхийлж харьцдаг. Япон хүнтэй ажил төрлийн талаар тохиролцон ярилцах үед япон хүний биеэ авч явж буй биеэ барьсан байдал нь тун эвгүй сэтгэгдэл төрүүлдэг ба *"Энэ хүн хувцасаа өлгүүртэй нь өмсчихсөн юм биш биз?"* гэж япон хүнтэй яриа өрнүүлж байсан нэгэн америк худалдаачин хэлсэн гэдэг.<sup>7</sup> Японд анги давхаргын тогтолцоо одоо хэр нь оршиж байгаа юм уу даа гэмээр, аливаа зүйлийг хэлж ярих өнгө төрх, уулзахдаа биеэ авч явж байгаа байдал нь урьдаас тогтсон байдаг. Иймэрхүү дээд доод давхаргын оршин тогтнолд суурилсан харилцаа Күнзийн ёс суртахуунтай гүнзгий холбоотой гэж үздэг байна. Тийм болохоор ихэнх япончууд өөрийн эрхгүй иймэрхүү уламжлалын нөлөөгөөр хүмүүс хоорондын харилцаа, үүнд үндэслэсэн ёс заншлыг өөртөө шингээн авч, хуулийн хүрээнд хүн бүр эрх тэгш гэх өнөөгийн нийгэмд ч дээрх шалгуурт тулгуурлан хүнтэй харьцаж байгаа билээ. Япон хүний үг тодорхой тоймтой зүйлээр дутмаг, ер нь л нөхцөл байдлыг л илэрхийлж хэлэхийг хүсч байдгаас болж гадаадаас ирсэн хүнийг төөрөлдүүлэх нь бий. Япон хүн далд утга агуулсан үгсээр ярилцагчдаа санаагаа илэрхийлэх тохиолдол их байдаг гэлцдэг. Хэрвээ япон хүн хэлэх үгээ үг үсэгчлэн тодорхой яриад байвал нөгөө хүндээ дарамттай, түүнийг юм ойлгодоггүй гэж бодоод байгаа юм шиг санагдаж болох талтай. Япон хүн харьцаж байгаа хүндээ хандан өөрийгөө дарж харьцахыг зөв ёсзүй гэж үздэг. Ямар нэгэн асуудал гарах юм уу, ярьж буй хүнээсээ ямар нэгэн юм хүсэх үед япон хүн ихэнхдээ "уучлаарай" гэж эхлэх юм уу, "өршөөгөөрөй, намайг" гэх мэтээр уучлал эрж буйтай адил

---

<sup>7</sup> Kagawa Hiroshi "The Inscrutable Japanese" 1977 p 77

байдлаар яриагаа эхэлдэг. Энэ бол япон хүний аливаа яриа хөөрөөг эхлүүлэх үндсэн арга гэж хэлж болно.

Япон хүн "уучлаарай" гэж хэлсэн учраас алдаа гарган өөрийн бурууг хүлээж байна гэж ойлгож болохгүй. Энэ бол "уучлаарай" гэж байгаад гол зүйл рүүгээ орох арга юм. Үүнийг мэдэхгүйгээс болж япон хүнтэй хийж буй яриа хэлэлцээндээ амжилт олоогүй тохиолдол олон бий. Яагаад гэвэл, энэ нь нөгөө уучлал эрээд бөхөлзөөд байсан япон хүн дараа нь харин бууж өгнө гэж бараг байдаггүйтэй холбоотой. Япон хүмүүстэй хэлэлцээ хийхэд ерөнхийдөө дөрвөн үе шатыг туулдаг. 1) nontask sounding; 2) task-related exchange of information; 3) persuasion; 4) concessions and agreement.<sup>8</sup> "Зай барьж" ярихаас гадна, ярианы явцад "зогсоц хийх" бас нэг асуудал байх ба энэ бол харилцан ярианы үе дэх "зай барих" асуудал юм. Япон хүн харилцагч тал нь ямар нэгэн юм хэлсний дараа бага зэрэг хугацаа өнгөрсний хойно ярилцагчийн хэлсэн зүйлийн талаар санаагаа хэлэх юм уу, энэ сэдвээр үргэлжлүүлэн яриа өрнүүлдэг байна.

## **Хоёр. Японы дипломат ёслол**

### *2.1 Япон маягийн хүлээн авалтын суудлын хуваарилалт*

Ач холбогдол: Албан ёсны оройн зоогны хялбарчилсан хэлбэрийн үед ч гэсэн анхнаасаа л суудлын хуваарилалтыг буруу хийвэл хичээж хийсэн цайллага, дайллага зочинд эвгүй сэтгэгдэл үлдээх тул япон хүмүүс энэ тал дээр сэтгэл гаргаж, анхаарч ажиллахыг хичээдэг.

Өрөөний хоймор болон үүдийг тодорхойлох нь:

Япон маягийн шалан дээр суудаг ширээний засалд "Токо" буюу жижиг тавцантай хэсэг хоймор болдог.

1. Зуухгүй бол хаалганы ойролцоох хэсэг үүд, харин эсрэг талын хэсэг хоймор болно.
2. Хаалганы эсрэг талыг хоймор гэж тодорхойлоход хэцүү. Европ маягийн өрөөний цэцэрлэг рүү харсан ханан тал хоймор болох бөгөөд цэцэрлэг рүү нуруугаараа харсан суудал үүдэн тал болно.

Дээрхи 1, 2-р аргыг харвал ямар ч Европ маягийн өрөөнд хоймор болон үүдэн суудлыг тодорхойлох шаардлага гардаг.

Хүлээн авалтыг зохион байгуулж байгаа эзэгтэйн суудал:

Дээр дурдсан шиг хоймор болон үүдээ тодорхойлсоны дараа ширээний гол хэсэгт зуух руу нуруугаа харуулан хүлээн авалтыг зохион байгуулж байгаа эзэгтэйн суух суудал байдаг нь үндсэн зарчим юм. Тэгээд, түүний эсрэг талд тухайн арга хэмжээний эзний суудал байдаг.

---

<sup>8</sup> Adachi, Yumi (2010) "Business Negotiations between the Americans and the Japanese," *Global Business Languages*: Vol. 2 Article 4. p 22

Дан эрэгтэйчүүд ирсэн хүлээн авалтанд эзний эзний суудалд гол зочинг суулгана. Мөн дан эмэгтэйчүүд цугласан тохиолдолд ижил байна.

### Зочдын суудал

Дээр бичсэнчлэн эзэгтэйн суудлыг шийдсэн тохиолдолд зочдын суудлыг хуваарилдаг ба үүнд Европ маягийн болон Англи-Америк маягийн суудал хуваарилалт гэж байдаг. Энэ хувилбарыг Японд нилээд өргөн ашигладаг.

### Япончуудын суудал хуваарилалтанд анхаарах зүйлс:

Суудал хуваарилахдаа дараах зүйлсийг анхаардаг бөгөөд үүнээс аль болох зайлсхийхийг хичээнэ.

1. Эхнэрийг нөхрийнх нь хажууд суулгах. Энэ тохиолдолд эхнэр нөхөр хоёрыг зөвхөн нэг нэгнийх нь хажууд суулгана гэвэл зарим үед хуваарилалтын явцад хамт суулгаж чадахгүйд хүрэх явдал гардаг. Энэ тохиолдолд ёс зүйн талаар мэдлэгтэй, хүлээцтэй зочин бол ойлгоод өнгөрнө.

2. Мөн боломжоороо эхнэр нөхрийг өөд өөдөөс нь харуулан суулгахгүй байх нь чухал гэж үздэг. Энэ тохиолдолд ирсэн зочдын холбоо харилцааны асуудлаас болоод хааяа гардаг бөгөөд үүнийг шийдэх хэцүү. Санаанд нийцсэн, чөлөөт суудал гэж хэлэхгүй тул ингэж суулгахгүй байх нь зүйтэй.

3. Ширээний хоёр захад гэрлэсэн эмэгтэйг суулгахыг зайлсхийж, эрэгтэй зочдыг суулгах хэрэгтэй. Үүний тулд эрэгтэй зочдын тоо, эмэгтэй зочдоос их байх шаардлагатай хийгээд энэ нь цайллага, дайллагыг амжилттай зохион байгуулах нэг түлхүүр гэж үзнэ.

4. Гэрлэсэн эмэгтэйчүүдийг гэрлээгүй бүсгүйчүүлээс чухалчилж авч үзэх нь ёс зүйн нэгэн зарчим тул гэрлээгүй бүсгүйг гэрлэсэн эмэгтэйн дараа суулгах нь ёс зүйд нийцнэ. Гэхдээ, гэрлээгүй бүсгүй цайллага болон дайллаганы эзэгтэйн үүргийг гүйцэтгэх тохиолдолд яг л эзэн шиг хүлээн авахаас өөр аргагүй.

Японд ресторанд зочид орж ирсний дараа гутлаа тайлан бөхийж мэндчилдэг.<sup>9</sup> Япон маягийн ширээ засалтанд гадаад дотоодын зочид уригдсан тохиолдолд Татами буюу хулсан дэвсгэр шалан дээр ширээ зассан бол гол зочныг "Токо"-гийн өмнө, эзнийг ширээний төгсгөл хэсэгт суулгадаг нь зочноо тэргүүн эгнээнд аваачдаг Европ Америкийн соёлоор энэ нь маш зохисгүй үйлдэл юм. Тийм ч учраас суудлыг хуваарилахдаа эзнийг ширээний голд суулгах Европ маягийн суудал хуваарилалт тохиромжтой гэж үздэг байна.

---

<sup>9</sup> Beeman, W. O. (2014). Negotiating a passage to the meal in four cultures. *Language and Food: Verbal and nonverbal experiences*. Amsterdam and Philadelphia: John Benjamins, p 45.

Хэрвээ, татами дээр суулгахаар болсон бол урьдах япон маягийн суудал хуваарилалтыг биш, харин "Токо"-гийн өмнө гол зочдыг эгнүүлэн суулгах нь зүйтэй.

### *2.3 Япон зоогийн ширээний ард баримтлах зарчмууд*

Япончууд үндэснийхээ хоолоос гадна хятад гаралтай хоол, европ хоолыг ч өдөр тутмынхаа хоолныхоо цэсэнд оруулдаг. Эдгээр хоол ундыг идэж уухад өөрийн гэсэн ёс журамтай байдаг. Үүний дотор япон үндэсний хоолыг идэхэд гадны хүмүүст мэдүүштэй онцлог ёс журам бий.

#### Савхыг хэрхэн хэрэглэх тухайд

10-р зууны үед Хятадтай албан ёсны дипломат харилцаа муудсанаас үүдэн сурвалжит хүмүүс халбага хэрэглэхээ болин Японы бүх иргэд зөвхөг савхаар хооллох болсон байна.<sup>10</sup> Япон хоолыг идэхэд баримтлах ёс журмын үндэс нь савхыг хэрхэн барих, хэрэглэхээс эхэлнэ. Япончууд өөрсдөө ч гэсэн савхыг яаж барьж, хоолоо идэх зэргийг хүүхэд багачууддаа зааж сургадаг байна. Савхыг ширээн дээр тавихдаа хүртэл тогтсон дүрэм бий. Япончууд төрсөн цагаасаа л савх барин хооллодог гэхэд хилсдэхгүй. Харин найр хурим зэрэг олны газар савхаа ёс журмаар барин хэрэглэх гэхээр сандардаг үе бий гэнэ. Савхыг зөв барьж хэрэглэн, хоол ундыг ёс заншлын дагуу идэж увал их сайхан харагддаг гэж япончууд ярьдаг. Хамгийн өргөн дэлгэр хэрэглэгддэг савханд салдаг шинэс модон савх, хоёр үзүүр нь нарийн шинэс модон савх, хоолыг савхдан авахад зориулсан хулсан савх зэрэг орно. Савхны дэр тулгуур байгаа үед савхыг гараар барьж авах талынх нь эсрэг тулгуур дээр дэрлүүлэн тавина. Салгадаг савхыг зүсэж зассан талаар нь дээш харуулан тавина. Хэрвээ дэрлүүлэн тавих зориулалтын тулгуур байхгүй бол царны баруун талаар давуулан тавина. Хоол идэж эхэлсэн хойно савхаа тавихдаа үзүүр талаар нь царны зүүн тал руу давуулан тавина.

Савх нь дотроо нүрибаши буюу өдөр тутам хооллохдоо хэрэглэдэг энгийн савх, варибаши буюу зочны, рестораны, торибаши буюу хоол тус бүрт дагалдан ирдэг савх, сайбаши буюу хоол хийхэд зориулагдсан урт савх гэж ангилагдана.

#### Савхыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

1. Баруун гараар савхны дунд хавиас өргөж авна. 2. Зүүн гараар савхны доод талаас зөөлхөн тулж авна. 3. Баруун гараа савхны баруун тал руу нь гулсуулан буулгаж, савхны толгой орчмоор доогуур нь оруулна. 4. Баруун гараар савхны дундаас дээгүүрхэн барих үед зүүн гараа авна. Япон хоол идэж байх үед савх барьсан гараараа будаатай аягаа цуг барих, савхаараа аягаа ийш тийш нь хөдөлгөх, хоолыг савхаараа зоож нүхлэх, аягатай хоолоо савхаараа хутгах зэрэг нь зохисгүйд тооцогддог.

---

<sup>10</sup> 石毛直道, & イシゲナオミチ. (2019). The history of food culture exchange for long-term periods: Japan as an example. *Senri Ethnological Studies*, 100, 11-22. p 17

### Салфетка буюу амны цаасыг хэрэглэх

Барууны хэв маягаар амны цаасыг тавган дээр тавьдаг бол Японд зүүн гар талд тавьдаг. Амны цаасыг ширээнд суухдаа болон хундага өргөх үед бус, харин таны өмнө хоол авчирсны дараа авч хэрэглэнэ.

Хэрэв амны цаасыг цагаа олоогүй үед авах юм бол "Би өлсөж байна, миний хоолыг хурдан авчирч өгнө үү" гэсэн сэтгэгдэл төрүүлэхэд хүрнэ гэдгийг анхаарахад илүүдэхгүй.<sup>11</sup>

### Ошибори буюу чийгтэй алчуурыг хэрэглэх

Ошибори буюу чийгтэй халуун алчуурыг япон ресторануудад их хэрэглэдэг. Хоол идэхээс өмнө болон гараараа хоол идсэний дараа гар арчих зориулалтаар хэрэглэдэг. Зун дулаан цагт хүйтэн, өвөл халууныг хэрэглэдэг ба халууцсан үедээ хүзүүгээ арчдаггүй.

Хөлөрсөн үедээ болон нүүр, хүзүүгээ арчих бол өөрийнхөө алчуураар арчаарай гэж зөвлөмөөр байна. Зарим ресторанд хоёр алчуур өгдөг ба нэгээр нь гар арчих, нөгөөгөөр нь хөлс арчих зориулалттай. Хэрэглэж дуусаад хуйлан ширээн дээрээ буцааж тавьдаг.

### Хоол идэх хурд

Япон ресторанд хүмүүстэй хоол идэхдээ тэдэнтэй зэрэг идэх хэрэгтэй. Бусад хүмүүсээс удаан эсвэл хэт хурдан идэх нь туйлын зохимжгүй. Ямар ч тохиолдолд хоол идэх хурдаа тохируулах нь их чухал.

### Тавгандаа хоол үлдээх

Хятадад тавгандаа хоол үлдээхийг хэвийн гэж үздэг бол япончуудад хоол үлдээх нь тийм ч таатай санагдахгүй. Захиалсан хоолоо тавгандаа үлдээвэл хамт хооллосон хүмүүстээ миний хоол таалагдахгүй байна гэсэн ойлголт төрүүлнэ.

### Цайллагын үед хоолны хэрэгслийг зөв хэрэглэх соёл

Цайллага ёслолын үед болон айлд зочлон очиход хоолож цайлах талаар баримтлах энгийн ёс журамыг мэдэхэд илүүдэхгүй.

Санамж:

1. Гартаа юм барьж байсан ч савхыг заавал хоёр гараараа авна.
2. Аягаа зүүн гарынхаа алган дээр тавина.
3. Баруун гараараа савхыг аван, савхны үзүүрийг зүүн гарынхаа долоовор хуруу болон дунд хурууныхаа хооронд оруулна.

---

<sup>11</sup> Teruaki Tamura "The elegant art of Japanese food and manners" 1995 p 113

4. Баруун гараа савхны толгой талаар тойруулан гулсуулж, доороос нь бариад зүүн гараасаа салгаад, хооллож эхэлнэ.

5. Зочин баруун гараараа хундагаа барин, ёслолын эзэн архи хундагалахад эвтэйхэн байхаар зүүн гараараа хундаганы ёроолоос зөөлхөн өргөж өгнө.

6. Хажуу талын зочиндоо архи хундагалахдаа зүүн гараар гүцээ барин, баруун гараар хажуугаас нь зөөлхөн өргөнгөө архиа зугуухан хундагална.

7. Шөлтэй аяганы таглааг авах. Баруун гараар тагийг аван, зүүн гараар зөөлхөн түлхэн онгойлгоно. Тагийг авахад хэцүү бол аяганы хоёр талаар агаарыг гаргах байдлаар хүч гарган түлхэхэд аяндаа онгойно. Аяганы таглаанд буй усан дуслыг доош нь урстал нь хэсэг барина. Таглааг зүүн гараараа тулангаа аяганы баруун талд дээш нь харуулан тавина. Хоолож дууссаны дараа тагийг анхны байдлаар нь аяган дээр тавина. Хоол идэхийн өмнө дээш харуулан тавьсан байдлаар нь буцаан тавьбал аягатайгаа барьцалдан тагийг гэмтээж болох талтайг анхаарах хэрэгтэй.

#### *2.4 Японы хундага өргөх ёсон*

Японд хундага өргөхийн өмнө “канпай” гэж хэлдэг. Хоол идэхийн өмнө хундага өргөх нь их чухал юм. Тухайн арга хэмжээг зохион байгуулж байгаа эзэн ирсэн зочиддоо япон үндэсний цагаан будааны архи болох сакэ-гаар дайлдаг. Японд сакэг нэрж гаргах арга Хятад болон Солонгосын хойгоор дамжиж нэвтэрсэн түүхтэй. Япончууд өөрсдийн гэсэн технологийг хөгжүүлж 20 орчим градустай, бусад эссенцигүй нэрмэл ликёруудаас хамгийн өндөр түвшний архийг үйлдвэрлэдэг болсон байна.<sup>12</sup> Сакэгаар дайлж байгаа тохиолдолд эмэгтэй хүн баруун гараараа архины хайрцагнаас барин, зүүн гараараа архийг хайрцагнаас гаргаж ирнэ. Архинаас хундагануудад нэг нэгээр нь дүүргэсний дараа хундага өргөж байгаа хүн бусаддаа хандан "Канпай" буюу "тогтооё" гэсэн үг хэлнэ. Архи уудаггүй хүн хундагатай архиныхаа оронд ус ч юм уу жүүс ууж болно. Хүмүүсийн дундах уур амьсгалыг эвдэхгүйн тулд дөнгөж уруулаа хүргэн амсах нь зохимжтой. Сакэ-гаар дайлах үед хундагаа баруун гартаа барин зүүн гараараа баруун гарынхаа доороос түшнэ. Япон ёсонд насаар ахмад буюу албан тушаал дээгүүр хүн нөгөө хүнийхээ хундагыг дүүргэж өгөх үед нэг гараараа хундагаа барьдаггүй. Эмэгтэй хүн хундагыг заавал хоёр гараараа барьдаг.

Хундага дүүргэх үед баруун гарынхаа долоовор хуруугаа хундаганыхаа ёроолд хүргэн сакэ-ний шилэнд ойртуулж барих нь хамгийн зохистой жаяг юм. Хэрэв хундага дүүрэн байвал долоовор хуруугаа үл ялигхан хөдөлгөвөл та нөгөө хүндээ "Миний хундага дүүрэн байна" гэсэн утгыг илэрхийлнэ.

#### *2.5 Япон улсын төрийн далбааг уулзалт, хэлэлцээнд хэрэглэх нь*

---

<sup>12</sup> Yoshio Sugimoto 2009 “The Cambridge Companion to Modern Japanese Culture” p 301

Төрийн далбаа ба түүнтэй холбоотой ёс журам

Японы төрийн далбааны түүхээс

Төрийн далбаа нь тухайн улсын тусгаар тогтнолын билэг тэмдэг байдаг. Дэлхийн улс орон бүр өөрсдийн төрийн далбааг зохиож үндсэн хууль болон бусад хуулиараа хуульчлан батлахдаа өөрийн орны ёс заншил хийгээд урт хугацааны түүхэн уламжлалд нийцүүлэх нь олонтаа. Япон улсын төрийн далбаа (японоор “хиномару” гэж нэрлэдэг) болох нарны бэлгэдэл дугуй дүрс нь японы үндсэн хууль, бусад хуулинд нийцүүлж бүтээсэн бус харин өнө удаан жилийн түүхэн ёс заншил ба уламжлалд тулгуурлагдсан болно. Японы төрийн далбаа нь мянга гаруй жилийн түүхтэй.<sup>13</sup> Эзэн хааны үе буюу 14-р зууны үеэс энэхүү нарны дугуй дүрсийг хэрэглэж ирсэн бололтой. Хожим Канёогийн 11-р он буюу 1634 онд Эдо дахь Бакүфүгийн Засгийн Газар /Цэргийн язгууртны засгийн газар/ нарны дугуйг өөрсдийн ордны сүлд болгож байв.

Эдогийн сүүл үед, Япон нь дотооддоо хөлөг онгоц хийх болсноор тэднийгээ гадны хөлөг онгоцноос ялгах таних тэмдэг зайлшгүй хэрэгтэй болжээ. Ингээд 1854 онд Бакүфү нь нарны дугуйг японы бүх хөлөг онгоцны сүлд болгосон бөгөөд 1859 онд улсын сүлд тэмдгээр баталж, энэхүү дүрс нь зөвхөн хөлөг онгоцон дээрх ялгах тэмдэг бус бүх л улс орныг төлөөлөх сүлд тэмдэг болов. Хожим Мэйжигийн 3-р он буюу 1870 онд Эзэн хаант засгийн газрын зарлигаар Японы хөлөг онгоцон дээр төрийн далбааг байрлуулахтай холбогдох ёслол хийгээд далбааг мандуулах аргачлалыг хуульчлан тогтоож өгчээ. Мэйжигийн 5-р он буюу 1872 оноос хөлөг онгоц төдийгүй хуурай газар дээрх улсын албан байгууллагууд ч төрийн далбааг мандуулах болсон байна. Энэ үеэс ард түмний дунд нарны дугуй дүрс бүхий тугийг төрийн далбаа гэж үзэх болжээ.

Японы төрийн далбааны хэмжээ

Мэйжигийн 3-р оны буюу 1870 оны 1-р сарын 27-нд тухайн үеийн Засгийн Газрын Худалдааны хөлөг онгоцонд холбогдох дүрмийн 57-д төрийн их, дунд, бага далбаа гэсэн 3 төрлийн далбаа ба тэдгээрт хамаарах ёс журам, стандарт хэмжээг хуульчлан тогтоож өгсөн бөгөөд энэхүү стандарт харьцаа нь өнөөдөр ч хэвээр хадгалагдаж байна.

1999 онд Японы Парламент нэлээд хэлэлцсэний эцэст, Kimigayo (төрийн дуулал) болон Hinomaru (төрийн далбааг) үндэсний бэлэг тэмдэг болгон баталсан байна.<sup>14</sup>

---

<sup>13</sup> Shtanko, M. A., Skvortsova, V. N., Shcherbinin, A. I., Rudneva, E., & Spichenko, T. A. (2016). The origins of Japanese national symbols. In *SHS Web of Conferences. Vol. 28: Research Paradigms Transformation in Social Sciences (RPTSS 2015)*.—Les Ulis, 2016. (Vol. 282015, p. 1094). EDP Sciences.

<sup>14</sup> Victoria Lyon Bestor, Theodore C. Bestor, Akiko Yamagata 2011 “Routledge Handbook of Japanese Culture and Society” p 73

Японы төрийн далбааг бусад орны төрийн далбаатай цуг байрлуулах нь

а. Бусад туг далбаатай байрлуулах тохиолдолд:

Төрийн далбаа нь төрийн бэлгэдэл байдгийнхаа хувьд тухайн улсын бусад туг далбаанаас /орон нутаг, байгууллагын туг/ хамгийн давуу эрхтэй нь байдаг. Өөрөөр хэлбэл улс дотор хэрэглэгдэж буй бусад туг далбаануудтай зэрэгцүүлэн байрлуулахдаа Японы төрийн далбааг хамгийн дээр нь эсвэл төв голд нь байрлуулна.

б. Хананд байрлуулах тохиолдолд:

Японы төрийн далбааг өөр улсын төрийн далбаатай зэрэгцүүлэн хананд байрлуулахдаа тухайн улсыг хүндэтгэн үзэх үүднээс төрийнх нь далбааг баруун талд нь (дээд байрлал), японы далбааг зүүн талд нь байрлуулдаг заншилтай. Өөрөөр хэлбэл хана руу чиглэн харахад гадаад улсын далбаа зүүн талд нь, японы далбаа баруун талд нь байна.

в. Хаалганы өмнө байрлуулах тохиолдолд:

Хаалганы өмнө хоёр улсын далбааг байрлуулахдаа б-д дурдсан журмыг баримтлах бөгөөд хаалганы дотор талаас харахад гадаад улсын далбаа баруун талд нь (гаднаас нь харахад зүүн), японы далбаа зүүн талд нь байхаар байрлуулна.

г. Солбиж байрлуулах тохиолдолд:

Хоёр улсын далбааг ишээр нь солбиж байрлуулахдаа б, в-д заасны нэг адил харагдаж байхаар байх бөгөөд солбиж харагдаж байгаа учир ишний уг дээрх 2 тохиолдлын байрлалаас эсрэг байрлалтай байна.

Ингэхдээ Японы далбааны иш дотор талд байх ёстой.

д. 3 болон түүнээс дээш улсын далбааг цуг байрлуулахдаа:

(i) 3 улсын далбааг цугт нь байрлуулж буй тохиолдолд Япон улсын Далбааг голлуулж, нөгөө хоёр улсын далбааг тухайн улсын нэрний эхний үсгээр цагаан толгойн дарааллыг баримтлан байрлуулдаг заншилтай. Хэрэв цагаан толгойн дараалалаар тухайн улсын нэр нөгөө орныхоос түрүүнд байгаа тохиолдолд тухайн улсын далбааг Японы далбааны баруун талд /хананд байрлуулсан тохиолдолд эгц урдаас нь харахад зүүн талд/, нөгөө улсын далбааг зүүн талд нь /эгц урдаас нь хана руу чиглэн харахад баруун талд/ байхаар 3 улсын далбааг байрлуулдаг. /Аль аль нь хана руу чиглэн харж буй байдлаар/

(ii) 4 болон түүнээс дээш улсын далбааг цугт нь байрлуулахад янз бүрийн хэлбэр байж болох боловч ерөнхийдөө цагаан толгойн үсгийн дарааллыг баримтлан байрлуулдаг байна. Хэрэв улсуудын тоо сондгой байгаа тохиолдолд Японы далбааг голлуулж бусад улсуудын далбааг цагаан толгойн дарааллаар Японы далбааны баруун зүүн, баруун зүүн гэсэн хэлбэрээр дотроос нь гадагш ээлжлүүлэн солбиж байрлуулдаг.

## Гурав. Японы төрийн ёслолын журмаас

### 3.1 Гадаадын дээд болон өндөр хэмжээний төлөөлөгчдийн айлчлал

#### 1. Гадаадын зочдыг хүрэлцэн ирэхэд угтах, үдэх ёс

Нисэх буудалд зочдыг угтах, үдэхдээ хүрэлцэн ирж буй зочид төлөөлөгчдийн зэрэг зиндаатай ижил түвшин, байр суурь бүхий албаны хүн хариуцан ажиллах нь чухал юм.

Японы Гадаад хэргийн яамны Ёслолын Хэлтэс нь дотроо Ёслолын тасаг, албан ёсны зочдын тасаг болон гадаад айлчлалын тасгаас бүрдэнэ.<sup>15</sup>

Албан Ёсны айлчлалын хувьд ихэнх тохиолдолд энэ үндсэн зарчмаас зөрдөггүй. Харин Албан Ажлын болон Албан бус айлчлалын тухайд ихэнхдээ Хааны гэр болон Засгийн газрыг төлөөлж Ордны өндөр албан тушаалтан буюу Японы Гадаад Хэргийн Яамны Ёслолын хэлтсийн дарга энэ ажлыг удирдан зохион байгуулдаг.

Угтах, үдэх ёслолыг тусгай онгоцоор ирсэн тохиолдолд тусгай онгоцны гадна талд зохион байгуулах бөгөөд Албан Ёсны айлчлалын үед Гадаад Хэргийн Яамны Ёслолын хэлтсийн дарга түрүүлж зочид төлөөлөгчдийн онгоцонд анхлан орж мэндчилсэний дараа зочид төлөөлөгчдийг онгоцны гадна хүлээж угтаж авч буй өндөр албан тушаалтан байгаа газарт дагуулан ирж, танилцуулж мэндчилсэний дараа машин цуваагаар байрлах буудал руу хөдөлнө.

Зарим оронд угтах ёслолын арга хэмжээг онгоцны буудалд хүндэт харуул жагсаан зохион байгуулдаг бол Японд угтах ёслолын арга хэмжээний өдөр цагийг товлон Акасака харшийн урд цэцэрлэгт зохион байгуулдаг. Албан бус айлчлалын үед угтах ёслолын арга хэмжээ хийдэггүй болно. 2019 онд Японы эзэн хааны ордон болон Асакаса харшид ойролцоогоор 150 орчим арга хэмжээг зохион байгуулсан байна.<sup>16</sup>

Японы олон улсын нисэх буудал нийслэлээс хол газарт байдаг тул энгийн зорчигчийн онгоцоор хүрэлцэн ирсэн тохиолдолд онгоцны буудалд Ёслолын хэлтсийн дарга болон дагалдагсад угтан авч, зарим тохиолдолд Өөрийгөө хамгаалах хүчний онгоцоор Нарита олон улсын нисэх буудлаас Ханэда дотоод нислэгийн нисэх буудал руу хүргэж нийслэлийн замын бөглөрлөөс зайлсхийх арга хэмжээ авах тохиолдол бий.

#### 2. Зочдын байр

Япон улс дээд хэмжээний болон албан ёсны айлчлаар ирсэн хүндэт зочноо Акасака харшид байрлуулдаг ба энэ үед Засгийн газрын хариуцсан ажилтан болон ГХЯ-ны Ёслолын

---

<sup>15</sup> Zhou, J., & Zhang, G. (Eds.). (2022). *A Study of Diplomatic Protocol and Etiquette: From Theory to Practice*. Springer Nature. p 244

<sup>16</sup> Booklet on Their Majesties the Emperor and Empress and the Imperial Family Ministry of Foreign Affairs, Japan 2021 p 13

хэлтсийн ажилтнууд тухайн орны соёл, ёс заншил зэргийг ихэд анхаарч хариуцан ажилладаг. Ажлын болоод Албан бус айлчлал, мөн дээд хэмжээний төлөөлөгчдийг ихэвчлэн дээд тэдний зэрэглэлийн зочид буудалд буулган байрлуулдаг. Хааны гэр бүлийн зиндааны зочин, төлөөлөгчийг орон нутагт айлчлах үеэр хүсэлтийг харгалзан Киотогийн Эзэн Хааны Ордонд байрлуулж байсан удаатай.

### 3. Айлчлах хөтөлбөр зэргийг бэлтгэх, бэлтгэл ажил

Хүндэт зочид, төлөөлөгчдийг хүлээн авах бэлтгэл ажлыг ихэнх улсад Гадаад Хэргийн Яамны Ёслолын хэлтэс голлон Хааны гэр бүл болон Ерөнхийлөгчийн Тамгын газар зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж гүйцэтгэнэ. Хөтөлбөрийг тухайн орны Засгийн газруудын зөвшөөрсөн айлчлалын хугацаанд зочид төлөөлөгчдийн хүсэлтийг харгалзан үзсэний үндсэн дээр бэлтгэнэ.

Албан ёсны арга хэмжээний айлчлалд угтах ёслолын үйл ажиллагаа, Төрийн тэргүүн, Засгийн газрын өндөр албан тушаалтнуудтай уулзах, Төрийн тэргүүн болон Ерөнхий сайдаас барих хүлээн авалт мөн түүнчлэн хариу хүлээн авалтууд багтдаг бөгөөд эдгээр нь хөтөлбөрийн нэг чухал хэсэг юм. Мөн уулзалтад оролцох, аж үйлдвэрийн болоод боловсролын байгууллага зэргийг үзэж сонирхох зэргээс гадна жуулчлах хөтөлбөр ч багтсан байдаг.

Хөтөлбөрт нийслэл хот дахь айлчлалаа дууссаны дараа орон нутагт дахь айлчлал орно. Ихэнх тохиолдолд уригдсан зочид төлөөлөгчдийн саналыг харгалзан үзсэний дагуу зохиодог. Бэлтгэл ажилд зочид төлөөлөгчийн харуул хамгаалалтын асуудал маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайн зочин, төлөөлөгчийн улс орны нөхцөл байдлыг сайтар судлан, маш нарийн Хамгаалалтын төлөвлөгөө боловсруулахаас гадна төлөвлөгөө хөтөлбөрийн хамгийн чухал хэсэг болох цагийг нарийн хянана. Энэ мэтчилэн хөтөлбөрөө нарийн боловсруулсны эцэст айлчлалтай холбогдох бүх этгээдэд энэ тухай тарааж мэдэгдэнэ.

### 4. Гадаадын өндөр хэмжээний зочид төлөөлөгчдөд зориулсан хүлээн авалтын урилга

Японд Албан Ёсны болоод Ажлын албан айлчлал хийж буй Төрийн тэргүүн болон Дэд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга зэрэг төлөөлөгчдийг Цог жавхлант Эзэн хаан болон Хатан хаанаас барих албан ёсны өдрийн зоог, мөн Ерөнхий сайд өргөөндөө оройн зоогийг зохион байгуулдаг.

Үүнээс гадна эдийн засгийн болоод найрамдлын нийгэмлэг, байгууллагууд орон нутагт айлчлал хийсэн тохиолдолд мужийн захирагч болон орон нутгийн холбогдох байгууллагууд хүлээн авч, зоог барих тохиолдол бий.

Албан бус айлчлалаар хүрэлцэн ирсэн Хааны гэр бүлийнхэнээс Цог жавхлант Эзэн хаан болон Хатан хааныг гэр бүлийн дотны хүрээнд өдрийн буюу оройн зоогт урьдаг. Зарим

тохиолдолд хүндэт зочидтой дотно харилцаатай Хааны гэр бүл ордонд буюу зочид буудал зэрэг газарт уригддаг.

### 3.2 Японы эзэн хаанд итгэмжлэх жуух бичиг барих нь

Нэг улсын төрийн тэргүүн нөгөө улсын төрийн тэргүүний дэргэд тохоон томилсон элчин сайд буюу бүрэн эрхт дипломат төлөөлөгч болохыг нотолж, шийтгэн олгосон итгэмжлэх жуух бичиг барих нь улс бүрт тухайн төрийн ёслолын журам, ёс горимоос хамааран янз бүр байна.

Эртний уламжлалт ёс заншилтай Японы эзэн хаанд итгэмжлэх жуух бичиг гардуулах ёслол өвөрмөц онцлогтой. Юуны өмнө эзэн хаанд итгэмжлэх жуух бичиг барих өдрийг эртнээс товлож хэдэн долоо хоног, нэг сар хүртэл хүлээнэ.

Харин хугацааг товлосон хариу ирмэгц Эзэн хааны консул элчин сайдын яаманд ирж ёслолын дэг ёсыг нарийн танилцуулж, дараа нь бэлтгэлтэй нь танилцдаг байна. Элчин сайд хар бараан өнгөтэй (full evening dress) эсвэл үндэсний хувцастай байж болно. Элчин сайдыг хааны ордон руу 5-6 дипломат дагалдан явна.

Ордоны машинаар явж хүлээн авах өрөө орж тэндээс гурван морин тэргээр ордон хүртэл явна. Морин тэргэнээс бууж хааны ордонд очиход элчин сайдыг хаанд консул танилцуулж элчин сайд 3 алхаж ёслоод хаантай мэндэлж арагш алхаж байрандаа очиж зогсох ба харин нуруугаа хаан руу харуулдаггүй нь хүндэтгэлийн шинж юм.<sup>17</sup>

Элчин сайд итгэмжлэх жуух бичиг барих ёслол дээр үг хэлдэггүй, фото зураг авдаггүй, эзэн хаантай гар барьдаггүй. Элчин сайдын яамны ажилтнуудыг танилцуулж эзэн хаанд Монгол Елсын Ерөнхийлөгчийн илгээлтийг дамжуулдаг ба итгэмжлэх жуух бичиг барих ёслол дуусаад Хааны консул элчин сайдыг дагалдан элчин сайдын яаманд ирнэ.

Шинээр томилогдсон элчин сайд итгэмжлэх жуух бичгээ Япон улсын цог жавхлантай эзэн хаанд өргөн барих ба Гадаад хэргийн сайд эсвэл аль нэг сайд заавал байлцана.<sup>18</sup>

1. “Шинээр томилогдож буй Элчин сайд Япон улсад албан ёсоор дипломат үйл ажиллагаа эхлүүлэх хүртэл мөрдөх журам”-д

- Япон улсад өөрийн биеэр хүрэлцэн ирэх
- Гадаад хэргийн яамны ёслолын алба Токиод суугаа тухайн улсын элчин сайдын яамнаас итгэмжлэх жуух бичиг болон эргүүлэн татах жуух бичгийн хуулбарыг хүлээн авч шалгана

<sup>17</sup> Д. Цолмон “Дипломат ёс горим, ёслол, баримт бичиг” УБ 2003 69

<sup>18</sup> <https://www.kunaicho.go.jp/e-about/kyuchu/shinninjo01.html>

- Шалгаж дууссаны дараа шинээр томилогдсон элчин сайд Гадаад хэргийн яамны ёслолын даргатай уулзан Гадаад хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргад дээрх хоёр жуух бичгийн хуулбарыг гардуулна
- Итгэмжлэх жуух бичгийн хуулбарыг гардуулснаар Элчин сайдад "Япон улсад суухаар томилогдсон элчин сайд (Ambassador Designate)" эрх олгоно. (Зарим зүйлээс бусад дипломат үйл ажиллагаа явуулах эрх нээгдэнэ)
- Дээрх эрхийг олгосонтой холбогдуулан Итгэмжлэх жуух бичгийг өргөн барих дарааллын жагсаалтанд бүртгэнэ
- Итгэмжлэх жуух бичгийг бүртгүүлсэн дарааллын дагуу Япон улсын Цог жавхлантай Эзэн хаанд өргөн барина гэж заасан байна.

2. Дээр дурдсаны дагуу Итгэмжлэх жуух бичиг болон Эгүүлэн татах жуух бичгийг шалгах явцад цөөнгүй тохиолддог доорх алдаануудыг анхаарахад илүүдэхгүй болов уу.

Доорх алдаа гарсан тохиолдолд Токиод суугаа тухайн улсын элчин сайдын яаманд жуух бичгийн хуулбарыг буцааж, тухайн орны Төрийн тэргүүн дахин гарын үсэг зурах шаардлага гарч Итгэмжлэх жуух бичгийг өргөн барихад их цаг хугацаа алдаж болохыг онцгой анхаарах хэрэгтэй.

А. Эзэн хааны алдар цол болон нэрийг бичих тухайд:

Эзэн хааны нэрийг бичихдээ "Naruhito, Emperor of Japan" гэж бичих бөгөөд "Naruhito" гэж товчлохгүй байх. Түүнчлэн эзэн хааныг "His Majesty" гэх бөгөөд "His Excellency" гэж бичдэггүй.

Б. Улсын нэрийн тухайд:

Япон улсын албан ёсны нэрийг англи хэл дээр "Japan" гэж бичдэг. "Republic of Japan", "Empire of Japan", буюу "The Japan" гэж бичвэл алдаа болно.

В. Гарын үсэг, гарын үсэг зурсан өдрийн тухайд:

- Тухайн орны төрийн тэргүүний гарын үсэг буюу гарын үсэг зурсан өдөр бичигдээгүй байх тохиолдолд гарын үсэг зурагдаагүйд тооцогдох учир гарын үсгийг зурж, он сар өдрийг заавал тавьсан байх ёстойг анхаарах хэрэгтэй.

### **Дүгнэлт, санал зөвлөмж**

Дипломат ёслол гэдэг бол түүхэн ойлголт юм. Хэдийгээр албан ёсны шинжтэй боловч тухайн улс түмний зан заншлын онцлог, амьдралын хэв маягтай холбоотой байдаг. Аливаа улс орныг судлах тэр дундаа тухайн улс орны байгууллага, хүмүүстэй харилцахад түүх соёл уламжлалыг нь судлах явдал чухал байдаг. Ялангуяа хүн төрөлхтөнд байвал зохих, өдөр

тутмын амьдралын салшгүй нэгэн бүрэлдэхүүн хэсэг болох дипломат ёс, ёслол нь нарийн дэг жаягтай.

Манайд дипломат ёс, ёслолыг хэлбэрийн төдий зүйл гэх эсвэл “сүржин ажиллагаа” гэсэн ойлголт газар авчээ. Дипломат ёс, ёслол гэхээр зөвхөн дипломат албаны хүнд байх чанар, тус албанд зүтгэж байгаа хүн хариуцаж, гүйцэтгэх ёстой үүрэг гэж ойлгодог өрөөсгөл хандлага байсаар байна.

Дипломат ёслол нь “гэрээ хэлэлцээрийн үргэлжлэл”, улс төр дипломатын ач холбогдолтой гэж үздэг.

Япончуудтай харилцаж хамтран ажиллахад тухайн улс үндэстний нийгмийн сэтгэлзүйн онцлогийг мэдэрснээр яриа хэлэцээг амжилттай явуулж чадна.

Бас нэг чухал зүйл бол сонгодог дипломат ёслол хэдийгээр нийтлэг боловч Япон улс нь Азийн орон боловч баруунжсан, өөрийн үндэсний зан үйлийн хэв маягийг хослуулж хадгалж үлдсэн их сонирхолтой үндэстэн юм.

Энэхүү судалгааны явцад Японы дипломат ёслолын талаар дараах дүгнэлтийг хийж байна.

1. Дэлхийн нөлөө бүхий бүс нутгийн их гүрэн Японы дипломат ёслол түүхийн уламжлалд тулгуурласан мөртлөө харьцангуй залуу бөгөөд тус улсын дипломат ёслолыг япон хүний ёс заншил, онцлогтой уялдуулан тал бүрээс нь судлан хоёр орны харилцаанд үр нөлөөтэй ашиглаж байх нь чухал гэж үзнэ.
2. Японы дипломат ёслолын асуудлыг тухайлан авч судлахад холбогдох материал сэлт ховор байна. Монгол хэл дээр Японы дипломат ёслолыг судалсан бүтээл ховор байна. Одоогийн байдлаар Японы дипломат ёслолын талаар монгол хэл дээр бичигдсэн ном, сурах бичиг, гарын авлага гэвэл М. Дүгэрсүрэн, О. Хосбаяр. “Дипломат ажиллагаа ба дипломат албаны үндэс”, Д. Цолмон “Дипломат ёс горим, Ёслол, баримт бичиг” зэргээс өөр ном хараахан үгүй байна. Ялангуяа Японы дипломат ёслолыг тухайлан судалсан зүйл тун бага байгаа төдийгүй энэ талын материал сургалтанд үнэхээр үгүйлэгдэж байгаа юм.
3. Японы дипломат ёслол нь эрт дээр үед Хятад, Солонгосын соёлын нөлөөн дор өөрийн гэсэн онцлогийг харуулсан хэв загварыг олсон ба сүүлд сонгодог буюу Европ, Америкийн дипломат ёслолыг авч хэрэглэсэн түүхтэй.
4. Ёслолын асуудал бол цаг хугацаа улиран өнгөрч, олон улсын харилцаа өөрчлөгдөхийн хирээр шинэчлэгдэж, баяжиж байдаг учраас тухайлсан ном, гарын авлага гаргаад орхих бус түүнийгээ үргэлж цаг тухайд нь шинэчлэн баяжуулж байх шаардлагатай гэж бодож байна. Тийм баймааж бидний гадаад харилцааны ажил илүү амжилттай, үр өгөжтэй явагдах үндэс суурийн нэг нь болох буй за.
5. Бие даасан судалгааны объектын түвшинд эл сэдвийг гүнзгийрүүлэн судлах, эх хэлнээ тусгайлан сурах бичиг болон гарын авлага, гаргах төдийгүй судалгааны ажил хийх шаардлагатай гэж үзнэ.

6. Дан ганц Японы дипломат ёслол гэлтгүй олон улсын дипломат ёслолын талаар сургалт зохион байгуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Тухайлбал, төрийн түшээд, гадаадад суух дипломат ажилтнууд, тэдний гэр бүлийн хүмүүст ийм төрлийн сургалт явуулах нь зохистой гэж үзэж байна.
7. Зөвхөн Японы Гадаад хэргийн яамны болон эзэн хааны ёслолын хэлтсийн нөхөд тухайн үед нь хийх бага хэмжээний танилцуулга зэрэгт дулдуйдан Японы дипломат ёслолын арга хэмжээнд оролцох нь тун хангалтгүй байх нь ойлгомжтой бөгөөд өөрсдөө тодорхой хэмжээний оюуны хийгээд сэтгэлзүйн бэлтгэлтэйгээр оролцохыг бодит байдал зүй ёсоор шаардаж байна. Японы дипломат ёслол, зан заншлын тухай тус улсад сууж байсан болон сууж байгаа элчин сайдууд болон дипломат ажилтнууд маань өөрсдийн туршлага, тэмдэглэл, дурсамжаа тодорхой бичиж үлдээж байвал хойч үеийнхэндээ сургамжтай судалгааны сурвалж болох бөгөөд ийм зүйл бидэнд ихээр үгүйлэгдэж байна.
8. Судалгааг илүү гүнзгий хийж, холбогдох материал, дүрэм, журмыг эх хэлнээс нь орчуулах, олон нийтийн хүртээл болгох шаардлагатай байна.

Японы зан заншил, дипломат ёслолоос суралцах зүйл их байгаа нь мэдээж. Үүнээс “авах гээхийн ухаан”-аар өөрт хэрэгтэй, тохирох зүйлүүдийг тусган авч, өөрсдийн мэдлэгээ арвижуулах нь зүйтэй мэт санагдаж байна.

## **НОМ ЗҮЙ**

### ***Монгол хэлээр:***

Ном, товхимол

1. Японы гадаад хэргийн яам "Япон орныг танин мэдэхүй", 2004
2. Японы гадаад хэргийн гам "Япон орны тухай товч танилцуулга", Токио 1999
3. Т. Намжим "Япон Орон тоймлон харвал", Улаанбаатар 1999
4. Д. Цолмон "Дипломат ёс горим, Ёслол, баримт бичиг", Улаанбаатар 2003
5. М. Дүгэрсүрэн, О. Хосбаяр "Дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс", Улаанбаатар, 1998
6. А. Муратхан, Ц. Ганболд, М. Лхагвасүрэн "Монгол Улсын Хилийн төлөөлөгч", УБ 2000

### ***Англи хэлээр:***

1. Japan Travel Bureau "Japan in your pocket" Volume 4 "Festivals of Japan", 1997
2. Japan Travel Bureau "Japan in your pocket" Volume 8 "Salaryman in Japan", 1997
3. Japan Travel Bureau "Japan in your pocket" Volume 1 "A look into Japan", 1997
4. Japan Travel Bureau "Japan in your pocket" Volume 10 "Today's Japan", 1997
5. Japan Travel Bureau "Japan in your pocket" Volume 2 "Living Japanese style", 1997
6. Japan Travel Bureau "Japan in your pocket" Volume 14 "Japanese Inn and travel", 1997
7. Japan Travel Bureau "Japan in your pocket" Volume 17 "Japanese family and culture", 1997
8. Japan Travel Bureau "Japan in your pocket" Volume 9 "Who's who of Japan", 1997

9. Japan Travel Bureau "Japan in your pocket" Volume 15 "Say it in Japanese", 1997
10. Ministry of Foreign Affairs Japan "Their Majesties the Emperor and Empress of Japan", 2004 Tokyo
11. "Japan" Side A Politics, Industry, History, Culture, Daily life and Sports
12. Side B "Basic data, Life in Japan and Basic Etiquette" Ministry of Foreign Affairs, Japan
13. Teruaki Tamura "The Elegant art of Japanese Food and manners", 1995 Tokyo
14. International Internship Programms "Japan at a Glance", 1997 Tokyo
15. Kodansha Encyclopedia of Japan "Japanese History", 1996 Tokyo
16. Donald Richie, Edwin O. Reischauer "Introducing Japan", (Уг номыг хамтран зохиогч Edwin O. Reischauer нь Японд төрсөн ба 1961-1966 онд Япон улсаас НҮБ-д суух элчин сайдаар ажиллаж байсан ба Японы тухай олон ном бүтээл бичсэн)
17. Kagawa Hiroshi "The Inscrutable Japanese", 1997
18. The International Society for Educational Information "The Japan of Today", 1989
19. Chris Taylor, Nicko Goncharoff, Mason Florence, Christian Rowthorn "Lonely Planet Japan", 1997
20. Martin Collcutt, Marius Jansen and Isao Kumakura "Cultural Atlas of Japan", 1988
21. Edwin O. Reischauer "The Japanese", 1978
22. Edwin O. Reischauer "The Japanese today change and continuity", 1988 Tokyo
23. Kodansha "Japan all illustrated encyclopedia 1 A-L", 1993 Tokyo
24. Kodansha "Japan all illustrated encyclopedia 2 M-Z", 1993 Tokyo
25. John R. Wood, Jean Serres "Diplomatic ceremonial and Protocol" (Principles, procedures and practice) NY, 1970
26. Ernest Satow "Guide to diplomatic practice", London & NY, 1979
27. Sheila K. Johnson "The Japanese through American eyes", Stanford California, 1988
28. Li, B. (2014). Diplomacy Beijing: Current Affairs Press
29. Jiali Zhou, Guobin Zhang 2022 "A Study of Diplomatic Protocol and Etiquette: From Theory to Practice"
30. Victoria Lyon Bestor, Theodore C. Bestor, Akiko Yamagata 2011 "Routledge Handbook of Japanese Culture and Society"
31. Yoshio Sugimoto 2009 "The Cambridge Companion to Modern Japanese Culture"
32. Adachi, Yumi (2010) "Business Negotiations between the Americans and the Japanese," *Global Business Languages: Vol. 2* Article
33. 石毛直道, & イシゲナオミチ. (2019). The history of food culture exchange for long-term periods: Japan as an example. *Senri Ethnological Studies*, 100, 11-22.
34. Beeman, W. O. (2014). Negotiating a passage to the meal in four cultures. *Language and Food: Verbal and nonverbal experiences. Amsterdam and Philadelphia: John Benjamins*, 31-52.
35. Shtanko, M. A., Skvortsova, V. N., Shcherbinin, A. I., Rudneva, E., & Spichenko, T. A. (2016). The origins of Japanese national symbols. In *SHS Web of Conferences. Vol. 28: Research Paradigms Transformation in Social Sciences (RPTSS 2015)*.—*Les Ulis, 2016*. (Vol. 282015, p. 1094). EDP Sciences.
36. Booklet on Their Majesties the Emperor and Empress and the Imperial Family Ministry of Foreign Affairs, Japan 2021

**Япон хэлээр:**

1. 友田 二郎 "エチケットとプロトコール" (Уг номын зохиогч нь Японы Гадаад Хэргийн Яаманд ёслолын хэлтсийн дарга, Япон улсаас Бельги, Люксембург улсад суух элчин сайдаар, Япон улсаас НҮБ-д суух элчин сайдаар хоёр удаа, 1979-1989 онд Японы эзэн хааны ордны ёслолын хэлтсийн даргаар тус тус ажиллаж байсан)
2. 安倍 勲 "プロトコール入門" 2003

***Орос хэлээр:***

1. Н. Т. Федоренко "Ясунари Кававата" Москва, 1978
2. В.В. Овчиников "Ветка сакуры Корни Дуба, Горячий пепел" Москва, 1987

***Интернэтийн вэбсайтууд:***

1. <http://www.geocities.jp/nakanolib/giften/sekiji.htm>
2. <http://www.web-japan.org>
3. <http://www8.cao.go.jp/intro/kunsho/english>
4. <https://www.mofa.go.jp/about/hq/record/index.html>
5. <https://www.kunaicho.go.jp/e-about/>